

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **БӨА-2023/221/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Аудитор: У.Ербол  
Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудитын гол асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН  
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ХЭЛТСИЙН  
ДАРГА Б.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА

2023.02.10 № 43  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Гадаадын иргэн, харьяатын газраас 53.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авч данс бүртгэлд тусгасан байна.

#### Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ИМ ХУАНГАН



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>18,923,792.78</u></b>	<b><u>28,105,603.88</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	18,923,792.78	28,105,603.88
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	18,923,792.78	28,105,603.88
35410	Бичиг хэргийн материал	267,000.00	776,800.00
35440	Түлш, шатах тослох материал	30,068.00	703,788.80
35470	Бусад хангамжийн материал	18,626,724.78	26,625,015.08
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>39,040,916.35</u></b>	<b><u>79,349,481.61</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	39,040,916.35	79,349,481.61
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	39,040,916.35	79,349,481.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,777,777.88	75,597,222.28
39204	Хуримтлагдсан элэгдэл		- (5,444,444.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15,089,144.79	16,555,562.61
39206	Хуримтлагдсан элэгдэл		- (8,650,244.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,173,993.68	1,783,038.16
39208	Хуримтлагдсан элэгдэл		- (491,652.56)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>57,964,709.13</u></b>	<b><u>107,455,085.49</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>57,964,709.13</u></b>	<b><u>107,455,085.49</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	57,964,709.13	107,455,085.49
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	57,964,709.13	107,455,085.49
51210	Өмнөх үеийн үр дүн		- 57,964,709.13
51220	Тайлант үеийн үр дүн	57,964,709.13	49,490,376.36
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>57,964,709.13</u></b>	<b><u>107,455,085.49</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>139,986,940.13</b>	<b>295,343,027.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>55,659,240.13</b>	<b>11,943,283.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	55,659,240.13	11,943,283.40
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	55,659,240.13	11,943,283.40
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	55,659,240.13	11,943,283.40
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>84,327,700.00</b>	<b>283,399,744.40</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	84,327,700.00	283,399,744.40
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	84,327,700.00	229,580,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	53,819,444.40
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>82,022,231.00</b>	<b>241,475,232.14</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>82,022,231.00</b>	<b>241,475,232.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	74,626,017.93	227,282,050.65
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	42,946,186.32	161,914,671.99
210101	Үндсэн цалин	27,298,363.60	93,656,265.55
210102	Нэмэгдэл	7,747,278.22	29,072,268.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,869,000.00	29,763,700.00
210104	Урамшуулал	3,031,544.50	9,422,438.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,353,464.51	20,607,287.65
210201	Тэтгэврийн даатгал	3,640,355.85	13,858,613.30
210202	Тэтгэмжийн даатгал	428,277.16	1,616,815.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	342,621.73	1,296,609.47
210204	Ажилгүйдлийн даатгал	85,655.46	322,160.94
210205	Эрүүл мэндийн даатгал	856,554.31	3,513,088.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,445,716.10	7,369,259.07
210301	Гэрэл, цахилгаан	275,716.10	1,533,988.87
210302	Түлш, халаалт	2,170,000.00	5,835,270.20
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,580,051.00	11,245,263.00
210401	Бичиг хэрэг	303,000.00	1,459,836.87
210402	Тээвэр, шатахуун	999,931.00	7,435,193.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	96,120.00	450,233.13
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	181,000.00	1,900,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,425,600.00</b>	<b>7,850,389.80</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	50,600.00	1,416,389.80
210604	Урсгал засвар	20,375,000.00	6,434,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,190,000.00</b>	<b>472,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,190,000.00	472,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>95,000.00</b>	<b>502,000.00</b>
210803	Даатгалын үйлчилгээ		79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		35,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		20,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	75,000.00	322,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,000.00	45,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>590,000.00</b>	<b>17,321,179.14</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	350,000.00	1,250,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	240,000.00	560,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		15,510,879.14
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,396,213.07</b>	<b>14,193,181.49</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>296,875.00</b>	<b>1,230,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	296,875.00	1,230,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>7,099,338.07</b>	<b>12,963,181.49</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,099,338.07	12,963,181.49
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>57,964,709.13</u></b>	<b><u>53,867,795.66</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	4,377,419.30
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	4,377,419.30
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(4,377,419.30)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>57,964,709.13</u></b>	<b><u>49,490,376.36</u></b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>84,327,700.00</b>	<b>229,580,300.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>84,327,700.00</b>	<b>229,580,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	84,327,700.00	229,580,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	84,327,700.00	229,580,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>84,327,700.00</b>	<b>227,580,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>84,327,700.00</b>	<b>227,580,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>76,931,486.93</b>	<b>213,387,118.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	42,946,186.32	161,914,671.99
210101	Үндсэн цалин	27,298,363.60	93,656,265.55
210102	Нэмэгдэл	7,747,278.22	29,072,268.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,869,000.00	29,763,700.00
210104	Урамшуулал	3,031,544.50	9,422,438.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,353,464.51	20,607,287.65
210201	Тэтгэврийн даатгал	3,640,355.85	13,858,613.30
210202	Тэтгэмжийн даатгал	428,277.16	1,616,815.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	342,621.73	1,296,609.47
210204	Ажилгүйдлийн даатгал	85,655.46	322,160.94
210205	Эрүүл мэндийн даатгал	856,554.31	3,513,088.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,445,716.10	8,456,988.87
210301	Гэрэл, цахилгаан	275,716.10	1,533,988.87
210302	Түлш, халаалт	2,170,000.00	6,923,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,186,120.00	10,479,970.00
210401	Бичиг хэрэг	570,000.00	1,343,736.87
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	6,970,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	96,120.00	450,233.13
210404	Ном, хэвлэл	40,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	480,000.00	1,716,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	22,125,000.00	5,316,200.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,750,000.00	1,860,000.00
210604	Урсгал засвар	20,375,000.00	3,456,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,190,000.00	472,000.00
210702	Дотоод албан томилолт	1,190,000.00	472,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	95,000.00	752,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		35,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		20,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	75,000.00	572,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,000.00	45,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	590,000.00	5,388,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	350,000.00	4,430,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	240,000.00	958,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,396,213.07</b>	<b>14,193,181.49</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	296,875.00	1,230,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	296,875.00	1,230,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	7,099,338.07	12,963,181.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,099,338.07	12,963,181.49
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-</b>	<b>2,000,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>2,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>2,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>2,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		2,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>(2,000,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>(0.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			57,964,709.13		57,964,709.13
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>57,964,709.13</b>	<b>0.00</b>	57,964,709.13
D01	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			57,964,709.13		57,964,709.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>57,964,709.13</b>	<b>0.00</b>	57,964,709.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			49,490,376.36		49,490,376.36
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>107,455,085.49</b>	<b>0.00</b>	107,455,085.49

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	229,580,300.00	229,580,300.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	229,580,300.00	229,580,300.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	228,350,300.00	215,387,118.51
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	172,658,000.00	161,914,671.99
210101	Үндсэн цалин	99,313,000.00	93,656,265.55
210102	Нэмэгдэл	31,205,000.00	29,072,268.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,825,000.00	29,763,700.00
210104	Урамшуулал	10,315,000.00	9,422,438.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,657,100.00	20,607,287.65
210201	Тэтгэврийн даатгал	14,943,800.00	13,858,613.30
210202	Тэтгэмжийн даатгал	1,864,200.00	1,616,815.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,466,800.00	1,296,609.47
210204	Ажилгүйдлийн даатгал	402,700.00	322,160.94
210205	Эрүүл мэндийн даатгал	3,979,600.00	3,513,088.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,539,000.00	8,456,988.87
210301	Гэрэл, цахилгаан	1,616,000.00	1,533,988.87
210302	Түлш, халаалт	6,923,000.00	6,923,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,515,000.00	10,479,970.00
210401	Бичиг хэрэг	1,378,400.00	1,343,736.87
210402	Тээвэр, шатахуун	6,970,000.00	6,970,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	450,600.00	450,233.13
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,716,000.00	1,716,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,316,200.00	7,316,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,860,000.00	1,860,000.00
210604	Урсгал засвар	3,456,200.00	3,456,200.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	500,000.00	472,000.00

210702	Дотоод албан томилолт	500,000.00	472,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>777,000.00</b>	<b>752,000.00</b>
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	35,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	572,000.00	572,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,000.00	45,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,388,000.00</b>	<b>5,388,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,430,000.00	4,430,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	958,000.00	958,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,230,000.00</b>	<b>14,193,181.49</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		- 12,963,181.49
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		12,963,181.49
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,230,000.00</b>	<b>1,230,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,230,000.00	1,230,000.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>229,580,300.00</b>	<b>229,580,300.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>229,580,300.00</b>	<b>229,580,300.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	229,580,300.00	229,580,300.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>12.00</b>	<b>11.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	6.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>12.00</b>	<b>11.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	7.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	4.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

##### **Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн зорилго нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэх, Олон улсын болон гадаад орны ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, нээлттэй, ил тод, шуурхай, чанартай, хүртээмжтэй ажил, үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

- Гадаадын иргэн, харьяатын газрын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эрчимжүүлэх.
- Технологийн дэвшилд тулгуурласан үйл ажиллагааны дэд бүтцийг бий болгох
- Инновацид суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын ижил чиг үүргийн байгууллагын хөгжлийн дэвшлийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх
- Шинэчлэлд нийцсэн, тогтвортой, чадварлаг, хариуцлагатай хүний нөөцийг бүрдүүлэх
- Эрхлэх асуудлын хүрээнд эдийн засаг, санхүүгийн чадавхыг бэхжүүлэх, өргөжүүлэх

**Үйл ажиллагааны чиглэл:** Эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, олон улсын стандартад нийцсэн цахим суурьтай виз, бүртгэл, хяналтын тогтолцоо болон гадаадын иргэдийн мэдээллийн нэгдсэн сан бий болгох чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

##### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтэс нь Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд Гадаадын иргэн, харьяатын газрын Хяналт шинжилгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Гадаад иргэн, харьяатын газрын даргын 2010 онд баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэн батлах тухай журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тус хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 149.5 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	18,923,8	28,105,6	9,181,7
Үндсэн хөрөнгө	39,040,9	79,349,5	40,308,6
<b>Нийт хөрөнгө</b>	<b><u>57,964,7</u></b>	<b><u>107,455,1</u></b>	<b>49,490,4</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	57,964,7	107,455,1	49,490,4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b><u>57,964,7</u></b>	<b><u>107,455,1</u></b>	<b>49,490,4</b>

Мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр дансанд өөрчлөлт гараагүй, өр төлбөргүй ажилласан байна.

Бараа материалын данс 9.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ГИХГ-аас хангамжийн материал, нийлүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 40.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ГИХГ-аас 53.8 сая төгрөгийн үнэтэй авто машиныг бүртгэлд авсантай холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 49.5 сая төгрөгөөр өссөн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 332.8 сая, нийт зарлагыг 332.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 49.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 11.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 18.0 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 7.4 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 3.9 сая төгрөгөөр, томилолт, зочны зардал 1.7 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.1 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

Цалингийн зардлыг 47.0 сая төгрөгөөр бууруулж баталсан нь Гадаадын иргэн харьяатын газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/15 дугаар тушаалаар тус хэлтсийн хяналтын улсын байцаагчийн 2 орон тоог Баруун бүс дэх газрын Увс аймаг дахь хэлтэс рүү шилжүүлсэнтэй холбоотой байна.

Байрны түрээсийн зардалд төлөвлөсөн 21.0 сая төгрөгийг тухайн оны төсвөөс хассан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл.**

Тайлант оны батлагдсан төсвийг 8.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 229.6 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 229.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, 12.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 216.6 сая төгрөг буюу 97.1 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	228.3	215.4	12.9	94.3%
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	1.2	1.2	0	100%
	<b>Дүн</b>	<b>229.6</b>	<b>216.6</b>	<b>12.9</b>	<b>97.1%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтэс нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 17/5 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 168.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус хэлтэс нь оны эцэст хэмнэсэн 12.9 сая төгрөгийг төвлөрүүлэн, батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулж, жилийн эцэст өр төлбөргүй ажилласан байна.

Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын хэмнэлтийг төвлөрүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан, алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 229.6 сая төгрөгийн 14 мэдээллийг оруулахаас бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ гараагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар зөрчил илрээгүй.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, гүйцэтгэлийн аудитаар цалингийн зардал болон бусад зардлуудыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

